



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201

Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,

Цахим шуудан: info@cabinet.gov.mn,

Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2024. 12. 27. № 35-1/176

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

“Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ӨЮУН-ЭРДЭНЭ



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024. 12. 27 № ХН/2708
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх хугацааг товлох тухай

“Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны 46 дугаар тэмдэглэлд:

“15.ХЭЛЭЛЦСЭН нь: “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД**

Энхтайваны өргөн чөлөө 7а,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: 26 21 35, Факс: (976-11) 32 21 27,
Цахим шуудан: info@mfa.gov.mn
Цахим хуудас: www.mfa.gov.mn

2024-12-25 № 09/6074
танай _____-ны № _____-г

**БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД
С.БЯМБАЦОГТ ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9-д заасны дагуу “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгов.



Б.БАТЦЭЦЭГ

1142404727



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.12.25 № 1/2584

танай _____-ны № _____-т

**БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД С.БЯМБАЦОГТ ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



О.АЛТАНГЭРЭЛ

151604640
А5.файл.2024



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2024.12.26 № 01/10698
танай 2024.12.25 -ны № 1^а/4539 -т

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД С.БЯМБАЦОГТ ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгов.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761003570

БАТЛАВ.
БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД

С.БЯМБАЦОГТ

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

О.АЛТАНГЭРЭЛ

БАТЛАВ.
ГАДААД ХАРИЛЦААНЫ
САЙД

Б.БАТЦЭЦЭГ

**“БАТЛАН ХАМГААЛАХЫН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БОЛОН ТЕХНОЛОГИ
ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ЯПОН УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН
БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага:

1.1.Хууль зүйн үндэслэл;

Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6-д “батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны олон улсын ерөнхий гэрээ” гэж, мөн зүйлийн 8.2-т “Заавал соёрхон батлах зохицуулалт бүхий олон талт олон улсын гэрээ болон заавал соёрхон батлуулахаар тохиролцсон хоёр талт олон улсын гэрээг соёрхон батална” гэж Улсын Их Хурал заавал соёрхон батлахаар;

Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-д “батлан хамгаалах бодлого, тогтолцооны эрх зүйн үндсийг тогтоох” гэж Монгол Улсын Их Хурлын бүрэн эрхэд, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.12-т “батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны Монгол Улсын олон улсын гэрээний хүрээнд бүрэн эрхийнхээ дагуу олон улсын байгууллага болон бусад улсын Засгийн газартай олон улсын гэрээ байгуулах” гэж Засгийн газрын бүрэн эрхэд, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3-т “батлан хамгаалах асуудлаар бусад улстай хамтран ажиллах талаар Засгийн газраас олгосон эрхийн хүрээнд хэлэлцээр байгуулах”, 14.1.7-д “батлан хамгаалах аж үйлдвэрийг хөгжүүлэх, зэвсэглэл, цэргийн техник, материал хэрэгслийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх” гэж батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрхэд,

Зэвсэгт хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5-д “цэрэг, цэрэг-техникийн хамтын ажиллагааны асуудлаар бүрэн эрхийнхээ хүрээнд бусад улсын Засгийн газартай гэрээ байгуулах” гэж Засгийн газрын бүрэн эрхэд тус тус заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 08 дугаар тогтоолоор “Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого батлах тухай” бодлого батлагдсан болно.

1.2.Практик шаардлага;

Монгол, Япон хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа нь айлчлал солилцоо, цэргийн мэргэжилтэн бэлтгэх, Хуурай зам,

Агаарын цэрэг хоорондын хамтын ажиллагаа, инженерийн цэрэг болон цэргийн эмнэлгийн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх, хамтарсан сургалт, дадлагад оролцох зэрэг өргөн хүрээтэй хөгжиж ирсэн.

Өнөөгийн байдлаар батлан хамгаалах салбарын хэмжээнд хоёр улсын Засгийн газар хооронд 2015 онд “Хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, гамшгийн үр дагаврыг арилгах болон НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр сургалт хэрэгжүүлэхэд хамтран ажиллах тухай хэлэлцээр”, Батлан хамгаалах яамд хооронд 2012 онд “Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах санамж бичиг” (2024 оны 02 дугаар сард шинэчилсэн), 2022 онд “Монгол Улсын Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал, Япон Улсын Агаарын Өөрийгөө хамгаалах хүчин хоорондын Агаарын цэргийн салбар дахь хамтын ажиллагаа болон солилцооны санамж бичиг”-ийг тус тус байгуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн 2022 онд Япон Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр хоёр орны харилцааг “Монгол Улс, Япон Улсын энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-д хүргэсэн. Энэхүү тусгай стратегийн түншлэлийн хүрээнд “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” байгуулах асуудал тусгагдаж, тухайн асуудлаар Гадаад харилцааны яамнаас чиглэл авч, хэлэлцээрийн төслийн хэлэлцүүлгийг хоёр талд байгуулагдсан ажлын хэсгүүдийн хамтарсан уулзалтуудаар хийж, хэлэлцээрийн төслийн агуулгыг эцэслэн тохиролцсон.

Хамтын ажиллагааны энэхүү хүрээг тэлэх, цаашдын хамтын ажиллагаагаа хөгжүүлэх, хууль эрх зүйн хувьд шинэчлэх, шинэчлэн баталгаажуулах хэрэгцээ шаардлага зайлшгүй үүссэн болно.

Хоёр. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээг тодорхойлох талаар:

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар:

Хуулийн төсөл батлагдсанаар манай улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд аливаа сөрөг үр дагавар үзүүлэхгүй, улсын төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй.

Харин Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулснаар хоёр улсын “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-ийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хангагдаж, Япон улстай хөгжүүлж буй батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа өргөжих, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, цэрэг-техникийн хамтын ажиллагаатай орны тоо нэмэгдэх, Япон Улсаас орчин үеийн батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэн авах, Монгол Улсын Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх боломж бүрдэх ач холбогдолтой юм.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт оруулах, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцэх бөгөөд хуулийн төсөл батлагдсантай холбогдуулан шинээр боловсруулах болон нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомж байхгүй болно.

—oOo—

**“БАТЛАН ХАМГААЛАХЫН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БОЛОН ТЕХНОЛОГИ
ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ЯПОН УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол, Япон хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа нь айлчлал солилцоо, цэргийн мэргэжилтэн бэлтгэх, Хуурай зам, Агаарын цэрэг хоорондын хамтын ажиллагаа, Инженерийн цэрэг болон цэргийн эмнэлгийн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх, хамтарсан сургалт, дадлагад оролцох зэрэг өргөн хүрээтэй хөгжиж ирсэн.

Өнөөгийн байдлаар батлан хамгаалах салбарын хэмжээнд хоёр улсын Засгийн газар хооронд 2015 онд “Хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, гамшгийн үр дагаварыг арилгах болон НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр сургалт хэрэгжүүлэхэд хамтран ажиллах тухай хэлэлцээр”, Батлан хамгаалах яамд хооронд 2012 онд “Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах санамж бичиг” (2024 оны 02 дугаар сард шинэчилсэн), 2022 онд “Монгол Улсын Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал, Япон Улсын Агаарын Өөрийгөө хамгаалах хүчин хоорондын Агаарын цэргийн салбар дахь хамтын ажиллагаа болон солилцооны санамж бичиг”-ийг тус тус байгуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн 2022 онд Япон Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр хоёр орны харилцааг “Монгол Улс, Япон Улсын энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-д хүргэж, түвшингээ ахиулсан. Энэхүү тусгай стратегийн түншлэлийн хүрээнд “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” байгуулах асуудлыг хоёр талаас харилцан тохиролцсон.

Энэхүү хэлэлцээр нь соёрхон батлах олон улсын гэрээ тул хэлэлцээрийн төслийг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар зөвшилцсөний үндсэн дээр 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр хэлэлцээрт гарын үсэг зураад байна.

Хэлэлцээр нь долоон зүйлтэй, батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж, технологи шилжүүлэх харилцааг зохицуулах хоёр талын цэрэг-техникийн хамтын ажиллагааны ерөнхий гэрээ болно. Хэлэлцээрийг Монголын талаас хэрэгжүүлэгчээр Монгол Улсын Батлан хамгаалах яам, Японы талаас Япон Улсын Батлан хамгаалах яам, Гадаад харилцааны яам, Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яам байна.

Хэлэлцээрийг таван жилийн хугацаатай байгуулах бөгөөд үүнээс хойш аль нэг талаас бичгээр энэхүү хэлэлцээрээс гарах тухай илэрхийлээгүй бол нэг, нэг жилээр сунгагдана.

Засгийн газар хоорондын тус хэлэлцээрийг соёрхон баталснаар хоёр улсын Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэлийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хангагдана.

Мөн Япон улстай хөгжүүлж буй батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа өргөжих, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, цэрэг-техникийн хамтын ажиллагаатай орны тоо нэмэгдэх, Япон Улсаас орчин үеийн батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэн авах.

Монгол Улсын Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх боломж бүрдэх ач холбогдолтой юм.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**“БАТЛАН ХАМГААЛАХЫН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БОЛОН ТЕХНОЛОГИ
ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ЯПОН УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Монгол, Япон хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа нь айлчлал солилцоо, цэргийн мэргэжилтэн бэлтгэх, Хуурай зам, Агаарын цэрэг хоорондын хамтын ажиллагаа, Инженерийн цэрэг болон цэргийн эмнэлгийн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх, хамтарсан сургалт, дадлагад оролцох зэрэг өргөн хүрээтэй хөгжиж ирсэн.

Өнөөгийн байдлаар батлан хамгаалах салбарын хэмжээнд хоёр улсын Засгийн газар хооронд 2015 онд “Хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, гамшгийн үр дагаварыг арилгах болон НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр сургалт хэрэгжүүлэхэд хамтран ажиллах тухай хэлэлцээр”, Батлан хамгаалах яамд хооронд 2012 онд “Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах санамж бичиг” (2024 оны 02 дугаар сард шинэчилсэн), 2022 онд “Монгол Улсын Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал, Япон Улсын Агаарын Өөрийгөө хамгаалах хүчин хоорондын Агаарын цэргийн салбар дахь хамтын ажиллагаа болон солилцооны санамж бичиг”-ийг тус тус байгуулсан.

Харилцааны хүрээ тэлэхийн хирээр хамтын ажиллагааны эрх зүйн баримт бичгүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх, шинээр байгуулах хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Нэг. Хэлэлцээрийн төслийн боловсруулалт, баталгаажуулалтын тухай

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн 2022 онд Япон Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр хоёр орны харилцааг “Монгол Улс, Япон Улсын энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-д хүргэж, түвшингээ ахиулсан. Энэхүү тусгай стратегийн түншлэлийн хүрээнд “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” байгуулах асуудлыг хоёр талаас харилцан тохиролцсон.

Хэлэлцээрийн төслийн хэлэлцүүлгийг хоёр талд байгуулагдсан ажлын хэсгүүдийн хамтарсан уулзалтуудаар хийж, хэлэлцээрийн төслийн агуулгыг эцэслэн тохиролцсон бөгөөд “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” байгуулах асуудлыг Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн.

Энэхүү хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.6-д заасан “батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны олон улсын гэрээ” бөгөөд заавал соёрхон батлах олон улсын гэрээ тул мөн хуулийн 11.1-д заасны дагуу хэлэлцээрийн төслийг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар зөвшилцсөний үндсэн дээр Монгол Улсын Ерөнхий сайдын “Гарын үсэг зурах эрх олгох тухай” 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 138 тоот захирамж гарч, 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр хэлэлцээрт гарын үсэг зураад байна.

Иймд дээрх хэлэлцээрийг Монгол Улсын Их Хурлаар соёрхон батлуулах хуулийн төслийг боловсруулна.

Хоёр. Хэлэлцээрийн тухай

Хэлэлцээр нь долоон зүйлтэй, батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж, технологи шилжүүлэх харилцааг зохицуулах хоёр талын цэрэг-техникийн хамтын ажиллагааны ерөнхий гэрээ болно. Хэлэлцээрийг Монголын талаас хэрэгжүүлэгчээр Монгол Улсын Батлан хамгаалах яам, Японы талаас Япон Улсын Батлан хамгаалах яам, Гадаад харилцааны яам, Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яам байна.

Хэлэлцээрийг хэрэгжүүлэгч талуудын зөвшилцлөөр шилжүүлэх техник, тоног төхөөрөмж, технологийг тодорхойлж, тухай бүр бэлтгэн нийлүүлэх нөхцөл, журмыг тогтсон дэлгэрэнгүй тохиролцоог байгуулна.

Ийнхүү зөвшилцөн, шилжүүлж авсан техник, тоног төхөөрөмжийг НҮБ-ын дүрэм, олон улсын гэрээний дагуу зөвхөн зориулалтын дагуу ашиглах, нууцлалыг хамгаалах, бусдад шилжүүлэхгүй байх үүргийг хүлээн авагч тал хүлээнэ.

Энэхүү хэлэлцээрийн хүрээнд шилжүүлэх техник, тоног төхөөрөмж, технологид татвар оногдуулахгүй.

Хэлэлцээрийг хэрэгжүүлэх үед гарч болзошгүй маргааныг талуудын зөвшилцлөөр олон улсын гэрээний дагуу шийдвэрлэнэ.

Хэлэлцээрийг хүчин төгөлдөр болсныг илтгэсэн дипломат ноот бичиг харилцан солилцсоны дараа албан ёсоор хэрэгжүүлж эхэлнэ.

Хэлэлцээрийг таван жилийн хугацаатай байгуулах бөгөөд үүнээс хойш аль нэг талаас бичгээр энэхүү хэлэлцээрээс гарах тухай илэрхийлээгүй бол нэг, нэг жилээр сунгагдана.

Гурав. Хуулийн төслийн боловсруулалтын талаар

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дагуу “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөлд хийсэн зардлын тооцооны тайлан болон хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааны тайланг боловсрууллаа. Дээрх судалгааны үр дүнд үндэслэн хуулийн төслийг боловсруулж, хуулийн төслийн үзэл баримтлалыг Гадаад харилцааны сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайд нартай хамтран батлаад байна.

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгана.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнүүд болон бусад хууль тогтоомжтой нийцэх бөгөөд хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлэх, батлагдсантай холбогдуулан шинээр боловсруулах болон нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомж байхгүй болно.

Хуулийн төсөл батлагдсанаар манай улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд аливаа сөрөг үр дагавар үзүүлэхгүй, улсын төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй.

Дөрөв. Хэлэлцээрийг байгуулснаар хүрэх үр дүн

Засгийн газар хоорондын тус хэлэлцээрийг соёрхон баталснаар хоёр улсын Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэлийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хангагдана.

Мөн Япон улстай хөгжүүлж буй батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа өргөжих, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, цэрэг-техникийн хамтын ажиллагаатай орны тоо нэмэгдэх, Япон Улсаас орчин үеийн батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэн авах, Монгол Улсын Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх боломж бүрдэх ач холбогдолтой юм.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Гарын үсэг

**БАТЛАН ХАМГААЛАХЫН ТЕХНИК,
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БОЛОН ТЕХНОЛОГИ ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
ЯПОН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар, (цаашид дангаар нь “Тал”, хамтад нь “Талууд”) гэх,

Хоёр улсын аюулгүй байдал, батлан хамгаалахын хамтын ажиллагааг харгалзан үзэж;

Талууд батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологийн чиглэлээр хамтран ажиллаж, олон улсын энх тайван, аюулгүй байдалд хувь нэмэр оруулахыг эрмэлзэж;

Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологийг шилжүүлэн өгөхтэй холбоотой зүйл, нөхцөлийг тодорхойлох шаардлагатай болохыг хүлээн зөвшөөрч;

Дараах асуудлаар хэлэлцэн тохиролцов. Үүнд:

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ

1. Нэг тал дотоодын холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, олон улсад хүлээсэн үүрэг болон энэхүү хэлэлцээрийн дагуу нөгөө талд тус хэлэлцээрийн 2 дахь хэсэгт заасан төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологиор хангана. Тухайн төсөл нь олон улсын энх тайван, аюулгүй байдал, хамтарсан судалгаа, хөгжүүлэлт, боловсруулалтын төсөлд хувь нэмэр оруулах болон аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэсэн байна.

2. Талууд тодорхой төсөл хэрэгжүүлэхдээ тухайн улсын аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлсийг анхааралдаа авч, хамтран тодорхойлох бөгөөд дипломат шугамаар баталгаажуулна.

2 ДУГААР ЗҮЙЛ

1. Энэхүү хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан шилжүүлэн өгөх батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологийн төслийг тодорхойлох “Хамтарсан хороо” байгуулна.


2. “Хамтарсан хороо” нь хоёр улсын үндэсний ажлын хэсгээс бүрдэнэ.

Монголын талын ажлын хэсэгт:

- Батлан хамгаалах яамны төлөөлөгч;
- Батлан хамгаалах яамнаас томилсон бусад холбогдох байгууллагын төлөөлөгчид байна.

Япон талын ажлын хэсэгт:

- Батлан хамгаалах яамны төлөөлөгч;
- Гадаад харилцааны яамны төлөөлөгч;



- Эдийн засаг, худалдаа, үйлдвэрийн яамны төлөөлөгч.

3. Шилжүүлэн өгөх батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологийг тодорхойлохтой холбоотой мэдээллийг ажлын хэсгүүд дипломат шугамаар харилцан солилцоно.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Талуудын хооронд солилцсон мэдээллийг үндэслэн "Хамтарсан хороо" шилжүүлэн өгөх батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологийн төслийг тодорхойлно.

5. Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэхдээ шилжүүлэн өгөх батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи, түүнийг шилжүүлэн өгөхөд оролцох этгээд, шилжүүлэн өгөхтэй холбоотой нарийвчилсан зүйл, нөхцөл зэрэг тохиролцоог Талуудын эрх бүхий байгууллагууд хийнэ. Монгол Улсын Засгийн газрын хувьд эрх бүхий байгууллагаар Батлан хамгаалахын яам, Япон Улсын Засгийн газрын хувьд эрх бүхий байгууллагаар Батлан хамгаалахын яам, Эдийн засаг, худалдаа, үйлдвэрийн яам байна.

3 ДУГААР ЗҮЙЛ

1. Нэг тал нөгөө талаас хүлээн авсан батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмд заасан зорилго, зарчмууд болон нарийвчилсан тохиролцоонд заасан зориулалтын дагуу ашиглах бөгөөд Талууд тухайн батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологийг өөр зорилгоор ашиглахгүй.

2. Нэг тал батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологийг шилжүүлэн өгсөн нөгөө талын зөвшөөрөлгүйгээр өөрийн талын албан тушаалтан, төлөөлөгч бус этгээдэд болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч эсхүл бусад улсын Засгийн газрын нэр дээр шилжүүлэх эсхүл эзэмшилд нь шилжүүлэн өгөхгүй.

4 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Талууд дотоодын холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, Талуудын хооронд болон тэдгээрийн холбогдох байгууллагуудын хооронд байгуулсан хэлэлцээрийн хүрээнд энэхүү хэлэлцээрийн дагуу шилжүүлэн өгсөн батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологитой холбоотой нөгөө талын өгсөн нууц мэдээллийг хамгаалах арга хэмжээ авна. Энэ тохиролцоонд Монгол Улсын Засгийн газрын хувьд холбогдох байгууллагаар Батлан хамгаалахын яам, Япон Улсын Засгийн газрын хувьд холбогдох байгууллагаар Батлан хамгаалахын яам байна.


5 ДУГААР ЗҮЙЛ

1. Энэхүү хэлэлцээр болон бүх тохиролцоог хоёр улсын холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам болон төсвийн санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлнэ.

2. Монгол Улсын Засгийн газар энэхүү хэлэлцээрийн дагуу хэрэгжүүлэх батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаанд татвар болон хураамж ногдуулахгүй.

6 ДУГААР ЗҮЙЛ

1. Энэхүү хэлэлцээрийг тайлбарлах, хэрэгжүүлэхтэй холбогдон Талуудын хооронд үүсэх аливаа асуудал болон бүх тохиролцоог зөвхөн зөвшилцөж шийдвэрлэнэ.



7 ДУГААР ЗҮЙЛ

1. Энэхүү хэлэлцээр нь Талуудын хүчин төгөлдөр болгоход шаардагдах дотоодын хуулийн шаардлага хангасан тухай дипломат шугамаар харилцан мэдэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

2. Талууд харилцан бичгээр мэдэгдэж, энэхүү хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Аливаа нэмэлт, өөрчлөлт нь энэхүү хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгохтой адил журмаар хүчин төгөлдөр болно.

3. Энэхүү хэлэлцээр нь таван жилийн хугацаанд хүчин төгөлдөр байх бөгөөд Талууд энэхүү хэлэлцээрийг дуусгавар болохоос ерэн хоногийн өмнө дуусгавар болгох саналаа дипломат шугамаар бичгээр хүргүүлээгүй бол жил бүр сунгагдана.


4. Энэхүү хэлэлцээр дуусгавар болсноос үл хамааран тус хэлэлцээрийн батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэхтэй холбоотой 3, 4, 5, 6 дугаар зүйлүүд хүчинтэй хэвээр байна.

Энэхүү хэлэлцээрт хоёр улсын Засгийн газраас эрх олгогдсон төлөөлөгчид гарын үсэг зурсан болно.

..... хотноо 2024 оны дугаар сарын өдөр, хоёр хувь үйлдэв.

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:**

**ЯПОН УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:**



AGREEMENT
BETWEEN THE GOVERNMENT OF MONGOLIA
AND THE GOVERNMENT OF JAPAN
CONCERNING THE TRANSFER OF DEFENSE EQUIPMENT AND TECHNOLOGY

The Government of Mongolia and the Government of Japan (hereinafter referred to individually as a "Party" and collectively as "the Parties"),

Mindful of the existing cooperative relationship between the Parties in the security and defense area;

Desiring that cooperation in the area of defense equipment and technology in which the Parties participate should contribute to international peace and security; and

Recognizing the need to set forth the terms and conditions which should govern the transfer of defense equipment and technology;

Have agreed as follows:

ARTICLE I

1. Each Party shall, subject to the relevant laws and regulations of its country and in accordance with the provisions of this Agreement and relevant international obligations of its country, make available to the other Party defense equipment and technology necessary to implement projects to be determined in accordance with the provisions of paragraph 2 below. Such projects shall be those for contributing to international peace and security; joint research, development and production projects; or for enhancing security and defense cooperation.

2. Specific projects shall be mutually determined by the Parties, taking into account various factors including the security of the respective countries, and confirmed by the Parties through the diplomatic channel.

ARTICLE II

1. A Joint Committee shall be established as the organ for determining the defense equipment and technology to be transferred for the projects determined in accordance with the provisions of paragraph 2 of Article I.

2. The Joint Committee shall be composed of two national sections.

The Mongolian Section shall be composed of:

a representative of the Ministry of Defence; and
a representative each from relevant authorities designated by the Ministry of Defence.

The Japanese Section shall be composed of:

a representative of the Ministry of Defense;
a representative of the Ministry of Foreign Affairs; and
a representative of the Ministry of Economy, Trade and Industry.

3. The relevant information necessary for determining the defense equipment and technology to be transferred shall be communicated to the national sections through the diplomatic channel.

4. Based on the relevant information communicated in accordance with the provisions of paragraph 3 above, the defense equipment and technology to be transferred shall be determined by the Joint Committee.

5. Detailed arrangements providing for, *inter alia*, the defense equipment and technology to be transferred, persons who shall be party to the transfer, and the detailed terms and conditions of the transfer, shall be made between the competent authorities of the Parties in order to implement this Agreement. The competent authority of the Government of Mongolia shall be the Ministry of Defence; the competent authorities of the Government of Japan shall be the Ministry of Defense and the Ministry of Economy, Trade and Industry.

ARTICLE III

1. Each Party shall make effective use of defense equipment and technology transferred from the other Party in a manner consistent with the purposes and principles of the Charter of the United Nations, and such purposes as may be determined in the detailed arrangements, and neither Party shall devote such defense equipment and technology to any other purpose.

2. Each Party shall not transfer to any person who is not an officer or agent including contractor and subcontractor of such Party, or to any other Government, title to or possession of any defense equipment and technology transferred pursuant to this Agreement, without the prior written consent of the Party which transferred such defense equipment and technology.

ARTICLE IV

Each Party shall, subject to the relevant laws and regulations of its country and in accordance with other applicable international agreements between the Parties and applicable arrangements between the relevant authorities of the Parties, take necessary measures to protect classified information furnished by the other Party in relation to the defense equipment and technology transferred pursuant to this Agreement. For such arrangement, the relevant authority of the Government of Mongolia is the Ministry of Defence, and the relevant authority of the Government of Japan is the Ministry of Defense.

ARTICLE V

1. This Agreement and all arrangements to be made hereunder shall be implemented subject to the relevant laws and regulations and budgetary appropriations of the respective countries.

2. The Government of Mongolia will not impose any taxes or charges on activities conducted under this Agreement in connection with the transfer of defense equipment and technology.

ARTICLE VI

Any matter relating to the interpretation or application of this Agreement and all arrangements to be made hereunder shall be resolved solely through consultation between the Parties.


ARTICLE VII

1. This Agreement shall enter into force on the date on which the Parties exchange diplomatic notes informing each other that their respective internal procedures necessary to give effect to this Agreement have been completed.
2. This Agreement may be amended by written agreement between the Parties. Any amendment of this Agreement shall follow the same procedures as its entry into force.
3. This Agreement shall remain in force for a period of five years and shall be automatically extended annually thereafter unless either Party notifies the other in writing through the diplomatic channel ninety days in advance of its intention to terminate this Agreement.
4. Notwithstanding the termination of this Agreement, the provisions of Articles III, IV, V, and VI shall remain in force in respect of the defense equipment and technology transferred under this Agreement.

IN WITNESS WHEREOF, the undersigned, being duly authorized thereto by their respective Governments, have signed this Agreement.

Done in duplicate at Ulaanbaatar, on this eleventh day of December, 2024, in the English language.

For the Government of Mongolia:



For the Government of Japan:



**БАТЛАН ХАМГААЛАХЫН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БОЛОН ТЕХНОЛОГИ
ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ЯПОН УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН
СУДАЛСАН ТАЙЛАН**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааг хийв.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол, Япон хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа нь айлчлал солилцоо, цэргийн сургалт, бэлтгэл, Хуурай замын цэрэг, Агаарын цэрэг хоорондын хамтын ажиллагаа, Инженерийн цэрэг болон цэргийн эмнэлгийн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх, хамтарсан сургалт, дадлагад оролцох зэрэг өргөн хүрээтэй хөгжиж ирсэн.

Хамтын ажиллагааны хүрээ тэлэхтэй уялдуулан хамтын ажиллагааны эрх зүйн баримт бичгүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх, шинээр байгуулах хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Хоёр улсын Засгийн газар хооронд 2015 онд “Хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, гамшгийн үр дагаврыг арилгах болон НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр сургалт хэрэгжүүлэхэд хамтран ажиллах тухай хэлэлцээр”, 2012 онд Батлан хамгаалах яамд хооронд “Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах санамж бичиг”-ийг байгуулсан бөгөөд 2024 оны 02 дугаар сард Батлан хамгаалахын сайдын Япон Улсад хийсэн ажлын айлчлалын үеэр уг санамж бичгийн шинэчилсэн баримт бичигт гарын үсэг зурсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 онд Япон Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр байгуулсан “Монгол Улс, Япон Улсын Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-ийн үйл ажиллагааны хөтөлбөрт “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” байгуулах асуудал тусгагдаж, тухайн асуудлаар Гадаад харилцааны яамнаас чиглэл авч, хоёр талын ажлын хэсэг томилогдон ажиллаж байна. Хоёр талын ажлын хэсгийн бэлтгэл уулзалтыг 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр цахимаар зохион байгуулсан ба хэлэлцээрийн албан ёсны зөвшилцлийг эхэлж, талууд 2024 оны 2, 3, 5, 6, 7 дугаар саруудад хэлэлцээрийн төслийг харилцан солилцсон. Хоёр талын ажлын хэсгийн уулзалтыг 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдөр дахин цахимаар зохион байгуулж, хэлэлцээрийн төслийн агуулгыг эцэслэн тохиролцсон.

Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6-д “батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны олон улсын ерөнхий гэрээ” гэж, мөн зүйлийн 8.2-т “Заавал соёрхон батлах зохицуулалт бүхий олон талт олон улсын гэрээ болон заавал соёрхон батлуулахаар тохиролцсон хоёр талт олон улсын гэрээг соёрхон батална.” гэж Улсын Их Хурал заавал соёрхон батлахаар;

Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-д “батлан хамгаалах бодлого, тогтолцооны эрх зүйн үндсийг тогтоох” гэж Монгол Улсын Их Хурлын бүрэн эрхэд, 13 дугаар зүйлийн 13.1.12-т “батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны Монгол Улсын олон улсын гэрээний хүрээнд бүрэн эрхийнхээ дагуу олон улсын байгууллага болон бусад улсын Засгийн газартай олон

улсын гэрээ байгуулах” гэж Засгийн газрын бүрэн эрхэд, 14.1.3-т “батлан хамгаалах асуудлаар бусад улстай хамтран ажиллах талаар Засгийн газраас олгосон эрхийн хүрээнд хэлэлцээр байгуулах”, 14.1.7-д “батлан хамгаалах аж үйлдвэрийг хөгжүүлэх, зэвсэглэл, цэргийн техник, материал хэрэгслийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх” гэж батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрхэд,

Зэвсэгт хүчний тухай хуулийн 12.1.5-д “цэрэг, цэрэг-техникийн хамтын ажиллагааны асуудлаар бүрэн эрхийнхээ хүрээнд бусад улсын Засгийн газартай гэрээ байгуулах” гэж Засгийн газрын бүрэн эрхэд тус тус заасан.

“Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-т “хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалыг Засгийн газар баталж мөрдүүлнэ” гэж, 13 дугаар зүйлийн 13.1-д “Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг энэ хуулийн 12.1.2-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж тус тус заасны хүрээнд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын (цаашид “Аргачлал” гэх) 2.1-т заасан үе шатны дагуу урьдчилан тандан судлав.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

1.1. Асуудлын хамрах хүрээг тодорхойлсон байдал:

Аргачлалын 3-т заасны дагуу асуудалд дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг оновчтой тогтоож, улмаар түүнийг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлохоор зорилоо.

Эрх зүйн зохицуулалтын талаар:

“Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулах эрх зүйн үндэслэл нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6-д “батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны олон улсын ерөнхий гэрээ” гэж, мөн зүйлийн 8.2-т “Заавал соёрхон батлах зохицуулалт бүхий олон талт олон улсын гэрээ болон заавал соёрхон батлуулахаар тохиролцсон хоёр талт олон улсын гэрээг соёрхон батална” гэж Улсын Их Хурал заавал соёрхон батлахаар заасан эрх зүйн хүрээнд юм.

Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулснаар хоёр улсын “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-ийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хангагдах, батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа улам гүнзгийрч, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, цэрэг-техникийн хамтын ажиллагаатай орны тоо нэмэгдэх, Япон Улсаас орчин үеийн батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи

шилжүүлэн авах эрх зүйн үндэс бүрдэж, Монгол Улсын Зэвсэгт хүчний хуулиар хүлээсэн үндсэн үүрэг гүйцэтгэх чадавхыг сайжруулахад чухал нөлөө үзүүлэх юм.

Иймд энэхүү соёрхон батлах хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулахаар боловсруулах нь зүйтэй гэж үзсэн.

1.2.Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд:

Соёрхон батлах тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөхгүй, сөрөг үр дагавар гарахгүй бөгөөд хоёр улсын “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-ийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хангагдах юм.

Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг дараах байдлаар тодорхойлж байна.

Эрх ашиг нь хөндөгдөж байгаа бүлэг		Тэдний эрх, ашиг сонирхолд ямар байдлаар нөлөөлж байгаа байдал
1.	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага	Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөхгүй, сөрөг үр дагавар гарахгүй

Хуулийн төсөл батлагдсанаар батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа улам гүнзгийрч, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, цэрэг-техникийн хамтын ажиллагаатай орны тоо нэмэгдэх, Япон Улсаас орчин үеийн батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэн авах, Монгол Улсын Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх боломж бүрдэх юм.

1.3.Асуудлыг үүсгэж буй шалтгаан, нөхцөлийг тогтоох:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 онд Япон Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр байгуулсан “Монгол Улс, Япон Улсын Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-ийн үйл ажиллагааны хөтөлбөрт “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” байгуулах асуудал тусгагдаж, тухайн асуудлаар Гадаад харилцааны яамнаас чиглэл авч, хоёр талын ажлын хэсэг томилогдон ажилласан.

Батлан хамгаалах чадавхыг сайжруулах асуудлыг шийдвэрлэхээс гадна “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд боловсруулахаар тусгагдсан тус хуулийн төсөл боловсруулагдаж, Монгол Улсын Их Хурлаар батлуулах зорилт хангагдах юм.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Энэхүү үнэлгээний тайлангийн 1-т заасан асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлага урган гарч байгаатай холбогдуулан аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх ерөнхий зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

Зорилго:

Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар соёрхон батлах тухай хуулийн төслийг батлуулж, энэхүү Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулснаар хоёр улсын “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-ийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хангагдах, батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа улам гүнзгийрч, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, цэрэг-техникийн хамтын ажиллагаатай орны тоо нэмэгдэх, Япон Улсаас орчин үеийн батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэн авах эрх зүйн үндэс бүрдэнэ.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

1. “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Эерэг тал	Сөрөг тал
➤ Батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа улам гүнзгийрнэ ➤ Монгол Улсын Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг сайжруулна. ➤ Зэвсэгт хүчинд техник, тоног төхөөрөмж нэмэгдэнэ.	Байхгүй

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу ерөнхий асуултад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

6.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө:

Соёрхон батлах тухай хуулийн төсөл батлагдсанаар бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, цэрэг-техникийн хамтын ажиллагаатай орны тоо нэмэгдэх ач холбогдол бий болж, хүний эрхийн талаар суурь ойлголт, хандлага, боловсрол дээшлэхээс гадна батлан хамгаалах чадавх сайжрах, хоёр улсын хамтын ажиллагаа улам гүнзгийрнэ. Мөн танин мэдэхүйн үр нөлөө бий болно.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 1)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх.	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх.		Үгүй	Ялгаварлан гадуурхахтай холбогдсон зохицуулалт тусгахгүй.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх.		Үгүй	Аль нэг талд давуу байдал үүсэхгүй.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг нөхцөл байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх.		Үгүй	Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ биш.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх.		Үгүй	Эрх, ашиг сонирхол нь хөндөгдөх, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлэх зохицуулалт байхгүй.
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх.		Үгүй	Бүлгүүдийг тусгайлан тодорхойлж, тэдэнд үзүүлэх үр нөлөөг тооцох зохицуулалт байхгүй.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх.	Тийм		Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал дахь зохицуулалт хангагдаж, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлнэ.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн	Тийм		Шударга, тэгш эрх, үр өгөөжтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн.

	асуудлаар зөвлөмжид байгаа эсэх.	өгсөн нийцэж			
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх.		Үгүй		Хариуцлагатай холбоотой зохицуулалт тусгахгүй.
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх.	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх.		Үгүй		Хүний эрхийг хязгаарлах талаар зохицуулалт тусгахгүй.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх.		Үгүй		Хүний эрхийг хязгаарлах талаар зохицуулалт тусгахгүй.
3.Эрх агуулагч.	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх.	Тийм			Монгол Улсын Засгийн газар болон Батлан хамгаалах яам.
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх.		Үгүй		Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон зохицуулалт байхгүй.
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх.		Үгүй		Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон зохицуулалт байхгүй.
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх. /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/		Үгүй		Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг агуулаагүй.
4.Үүрэг хүлээгч.	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх.	Тийм			Монгол Улсын засгийн газар, Батлан хамгаалах яам тодорхой үүрэг хүлээнэ.
5.Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх.	5.1.Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх.		Үгүй		Жендерийн эрх тэгш байдлыг хангахтай холбогдсон зохицуулалт тусгагдахгүй.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх.		Үгүй		Жендерийн эрх тэгш байдлыг хангахтай холбогдсон зохицуулалт тусгагдахгүй.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл өрсөлдөх чадвар.	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх. (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)		Үгүй	Ямар нэгэн нөлөө байхгүй.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх.		Үгүй	Хамааралгүй.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал.	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх.		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх.		Үгүй	Үнийн хөөргөдлийг бий болгохгүй.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх.		Үгүй	Хүндрэл, бэрхшээл бий болохгүй.
	2.4.Зах зээлд шинээр монополыг бий болгох эсэх.		Үгүй	Монополыг бий болгохгүй.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал.	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх.		Үгүй	Шинээр зардал үүсэхгүй.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх.		Үгүй	Ямар нэгэн хязгаарлалт, хориг тавихгүй.

	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал.	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх.		Үгүй	Ямар нэгэн нэмэлт зардал бий болохгүй.
5.Өмчлөх эрх.	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх.		Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх.		Үгүй	Тийм хязгаарлалт бий болохгүй.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх.		Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.
6.Инновац болон судалгаа шинжилгээ.	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх.		Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх.		Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв.	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх.		Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	7.4.Хувь хүний /гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх.		Үгүй	Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд.	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх.		Үгүй	Ажлын байрыг шинээр бий болгохгүй.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.

	багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх.			
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
9.Төрийн захиргааны байгууллага.	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх.		Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх.		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт хийх шаардлага тавигдахгүй.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх.		Үгүй	Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болохгүй.
10.Макро эдийн засгийн хүрээнд.	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх.	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх.		Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
11.Олон улсын харилцаа.	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх.	Тийм		Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ (Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл.	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх.		Үгүй	Шинээр ажлын байр бий болохгүй.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх.		Үгүй	Ажлын байрны цомхотгол бий болохгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх.		Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх.		Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх.	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх.		Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн		Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.

	аюулгүй байдалд нөлөөлөх эсэх			
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх.		Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх.		Үгүй	Шинээр ажлын стандарт гаргахгүй.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх.		Үгүй	Өөрчлөлт бий болохгүй.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал.	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх.		Үгүй	Тэгш бус байдал үүсгэхгүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт.		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн байдлаар нөлөөхгүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун.	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх.	Тийм		Зэвсэгт хүчний хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлага нэмэгдэнэ.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх.		Үгүй	Төрийн захиргааны зарим байгууллагын албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөө үзүүлэхгүй.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн байдлаар нөлөөлөхгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал.	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх.		Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.

	эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх.			
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх.		Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем.	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх.		Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олгох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх.		Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал.	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх.		Үгүй	Ялгаварлан гадуурхалт, дарамт шахалт үзүүлэхээс ангид байх зохицуулалтыг тусгана.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.
8.Соёл.	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.

	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
--	--	--	------	------------------------------

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар.	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх.		Үгүй	Агаарын бохирдлыг нэмэгдүүлэхгүй.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч.	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх.		Үгүй	Түлшний хэрэглээг нэмэгдүүлэхгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх.		Үгүй	Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэхгүй.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх.		Үгүй	Агаарын бохирдлыг нэмэгдүүлэхгүй.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах.	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.
4.Усны нөөц.	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх.		Үгүй	Бохирдлыг нэмэгдүүлэхгүй.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
5.Хөрсний бохирдол.	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.

6.Газрын ашиглалт.	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх.		Үгүй	Ашиглагдаагүй байсан газрын ашиглахгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх.		Үгүй	Газрын зориулалтыг өөрчлөхгүй.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх.		Үгүй	Зориулалтыг өөрчлөхгүй.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг.	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх.		Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх.		Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.

ТАВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын 7-д зааснаар хувилбаруудын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх

гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Асуудлын мөн чанар, цар хүрээ болон Зэвсэгт хүчний хуулиар хүлээсэн үндсэн үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмжөөр хангагдах нөхцөл бүрдэх зохицуулалтын хүрээнд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасны дагуу “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хуралд соёрхон батлахаар хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

ЗУРГАА.ЗӨВЛӨМЖ

Аргачлалын 9-д заасны дагуу дараах зөвлөмжийг боловсрууллаа.

Соёрхон батлах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнүүд болон бусад хуультай уялдсан байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт заасны дагуу Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан хамт өргөн мэдүүлэх хуулийн төсөл байхгүй болно.

Дэвшүүлсэн ерөнхий зорилгодоо хүрэхийн тулд Соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулж, батлан гаргах хувилбарыг сонгох замаар тулгамдсан

асуудлыг шийдэх нь хамгийн үр дүнтэй гэж үзэж байна. Тус хуульд дараах асуудлыг тусган зохицуулах шаардлагатай:

1 дүгээр зүйл. "Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай." гэсэн зохицуулалт болно.

---oOo---

**ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ
ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Ерөнхий мэдээлэл

Монгол Улс болон Япон Улсын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа нь айлчлал солилцоо, цэргийн сургалт, бэлтгэл, Хуурай замын цэрэг, Агаарын цэрэг хоорондын хамтын ажиллагаа, Инженерийн цэрэг болон цэргийн эмнэлгийн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх, хамтарсан сургалт, дадлагад оролцох зэрэг өргөн хүрээтэй хөгжиж ирсэн.

Үүний нэг тод илрэл нь Монгол Улс, Япон улсын Засгийн газар хооронд 2015 онд “Хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, гамшгийн үр дагаврыг арилгах болон НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр сургалт хэрэгжүүлэхэд хамтран ажиллах тухай хэлэлцээр” болон 2012 онд Батлан хамгаалах яамд хооронд “Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах санамж бичиг”-ийг байгуулсан юм. 2024 оны 02 дугаар сард Батлан хамгаалахын сайдын Япон Улсад хийсэн ажлын айлчлалын үеэр уг санамж бичгийн шинэчилсэн баримт бичигт гарын үсэг зурсан болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 онд Япон Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр байгуулсан “Монгол Улс, Япон Улсын Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-ийн үйл ажиллагааны хөтөлбөрт “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” байгуулах асуудал тусгагдаж, тухайн асуудлаар Гадаад харилцааны яамнаас чиглэл авч, хоёр талын ажлын хэсэг томилогдон ажилласан.

Хоёр талын ажлын хэсгийн бэлтгэл уулзалтыг 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр цахимаар зохион байгуулсан ба хэлэлцээрийн албан ёсны зөвшилцлийг эхэлж, талууд 2024 онд нийт 5 удаа хэлэлцээрийн төслийг харилцан солилцсон. Хоёр талын ажлын хэсгийн уулзалтыг 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдөр дахин цахимаар зохион байгуулж, хэлэлцээрийн төслийн агуулгыг эцэслэн тохиролцсон болно.

Иймд Хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлуулснаар хоёр улсын “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-ийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хангагдах, батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа улам гүнзгийрч, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, цэрэг-техникийн хамтын ажиллагаатай орны тоо нэмэгдэх, Япон Улсаас орчин үеийн батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэн авах, Монгол Улсын Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавх сайжирна.

Нэг.Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгох үе шат

1.1.Зорилгод хүрэх байдал.

Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн, холбогдох зохицуулалтуудыг тусгасан байна.

Хуулийн төслийг түүний үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон байдалтай харьцуулан үзэхэд Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл нь Олон улсын гэрээний тухай болон Хууль тогтоомжийн тухай хуульд заасан зохицуулалттай нийцэж байгаа болно.

1.2.Ойлгомжтой байдал.

Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйл, хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан хэлбэрээр боловсруулагдсан нь ойлгомжтой байна.

Хоёр.Тухайн төслийн аль хэсгийн үр нөлөөг үнэлэхээ тогтоох үе шат

Хууль тогтоомжийн төслийн бүх зүйл, заалтын үр нөлөөг үнэлэх нь их хугацаа, зардал, хүн хүч шаардсан ажил байдаг бөгөөд бүхэлд нь үнэлэх боломжгүй хэдий ч тухайн хуулийн төсөл нь нэг зүйлээс бүрдэж байгаа тул тодорхой зүйл, заалтыг сонгон авч үр нөлөөг үнэлэх шаардлагагүй болно.

Иймээс хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоохдоо тухайн төслийн хамгийн гол чухал, тавьсан зорилготой холбоотой, агуулгын хувьд хамгийн ач холбогдолтой, анхаарах шаардлагатай нэг зүйл байгаа болно.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Соёрхон батлах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд тусгагдсан зохицуулалт байна.

Хуулийн төслийг хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон байдалтай харьцуулан үзэхэд манай улс нь Япон Улсаас орчин үеийн батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэн авах эрх зүйн үндсийг бүрдүүлэх зохицуулалтын түвшинд хүргэх зорилго тавьсан байна.

1 дүгээр зүйл.”Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Зэвсэгт хүчний тухай хуулийн 12.1.5-д “цэрэг, цэрэг-техникийн хамтын ажиллагааны асуудлаар бүрэн эрхийнхээ хүрээнд бусад улсын Засгийн газартай гэрээ байгуулах” гэж Засгийн газрын бүрэн эрхэд заасан зохицуулалттай нийцэж, Монгол Улсын Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг сайжруулах түвшинд хүрэх гэж үнэлж байна.

“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийн 1 дугаар зүйлд тусгагдсан зохицуулалтын хүрээнд:

1 дүгээр зүйл.”Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулснаар хоёр улсын “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-ийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хангагдах, батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа улам гүнзгийрч, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, цэрэг-техникийн хамтын ажиллагаатай орны тоо нэмэгдэх, Япон Улсаас орчин үеийн батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи

шилжүүлэн авах, Монгол Улсын Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлнэ.

Хуулийн төслийг хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон байдалтай харьцуулан үзэхэд батлан хамгаалах чадавх сайжирч, орчин үеийн цэргийн техник, тоног төхөөрөмжөөр хангагдах эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилго тавьсан байна.

Энэхүү зохицуулалтыг сонгон авснаар хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан хууль зүйн болон практик хэрэгцээ шаардлага хангагдах юм.

Гурав.Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг тооцох хэсэг	Шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	1 дүгээр зүйл."Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.	Зорилгод дүн шинжилгээ хийх
2.	Ойлгомжтой байдлыг судлах.	1 дүгээр зүйл."Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.	Ойлгомжтой байдлыг судлах

3.1.Зорилгод дүн шинжилгээ хийх.

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй бөгөөд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хуулийн төсөл батлагдан хэрэгжсэнээр тавьсан зорилгодоо хүрэх боломжтой байдлаар томъёологдож чадсан байна. Энэ нь хуулийн төслийн үзэл баримтлалд, түүний агуулгатай үр нөлөөг үнэлж байгаа зохицуулалттай харьцуулан дүн шинжилгээ хийснээр тодорхойлогдож байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалд Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6-д "батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны олон улсын ерөнхий гэрээ" гэж, мөн зүйлийн 8.2-т "Заавал соёрхон батлах зохицуулалт бүхий олон талт олон улсын гэрээ болон заавал соёрхон батлуулахаар тохиролцсон хоёр талт олон улсын гэрээг соёрхон батална" гэж Улсын Их Хурал заавал соёрхон батлахаар, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-д "батлан хамгаалах бодлого, тогтолцооны эрх зүйн үндсийг тогтоох" гэж Монгол Улсын Их Хурлын бүрэн эрхэд, 13 дугаар зүйлийн 13.1.12-т "батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны Монгол Улсын олон улсын гэрээний хүрээнд бүрэн эрхийнхээ дагуу олон улсын байгууллага болон бусад улсын Засгийн

газартай олон улсын гэрээ байгуулах” гэж Засгийн газрын бүрэн эрх дэх зохицуулалтыг тус тус заасан.

Ингэснээр хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан хууль зүйн болон практик хэрэгцээ, шаардлага хангагдаж, Батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх зорилгодоо хүрнэ.

3.2.Ойлгомжтой байдлын судлах.

Хуулийн төсөл нь 1 зүйлээс бүрдэж, түүнд “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай. гэсэн зохицуулалтыг тусгаж байгаа болно.

Дээрх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгахдаа тухайн зохицуулалтын хүрээнд УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор хэлэлцүүлсэн болно.

Санал авахдаа хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төслийг хавсарган хүргүүлсэн болно.

Үүнийг шалгах хэрэгслийн хүрээнд Хууль тогтоомжийн тухай 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн дараах заалтад дурдсан шаардлагыг хангасан эсэхэд хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хууль 29 дүгээр зүйл. Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага:	
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.2.Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.3.Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.4.Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.5.Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.7.Бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг иш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.8.Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Уг шаардлагыг хангасан.
29.1.9.Шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин	Уг шаардлагыг хангасан.

төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	
29.1.10.Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.11.Хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Уг шаардлагыг хангасан.
30 дугаар зүйл.Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага:	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Уг шаардлагыг хангасан.
30.1.2.Нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
30.1.3.Үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Уг шаардлагыг хангасан.
30.1.4.Хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
30.1.5.Жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Уг шаардлагыг хангасан.

Дөрөв.Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх үе шат

Тус үр нөлөөг тооцох үнэлгээг “Хэлэлцээр соёрхон батлах тухай” хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хийв.

Энэхүү үнэлгээний ажлын хүрээнд “Хэлэлцээр соёрхон батлах тухай” хуулийн төслийн асуудлаар Гадаад харилцааны яамнаас чиглэл авч, хоёр талын ажлын хэсэг томилогдон ажилласан.

Хоёр талын ажлын хэсгийн бэлтгэл уулзалтыг 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр цахимаар зохион байгуулсан ба хэлэлцээрийн албан ёсны зөвшилцлийг эхэлж, талууд 2024 онд нийт 5 удаа хэлэлцээрийн төслийг харилцан солилцсон. Хоёр талын ажлын хэсгийн уулзалтыг 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдөр дахин цахимаар зохион байгуулж, хэлэлцээрийн төслийн агуулгыг эцэслэн тохиролцсон болно.

Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөлд Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу холбогдох судалгаа хийгдсэн тул энэхүү үр нөлөөний судалгаа дүгнэлт, хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлэн хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх нь оновчтой байна.

---oOo---

**ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилт 7.1-д “Улс орны батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгож, чадавхыг бэхжүүлнэ” гэж заасны 7.1.4-д “Мэргэшсэн чадварлаг байнгын бүрэлдэхүүнтэй, хөдөлгөөн, гал, цохилтын өндөр боломжтой хуурай замын цэргийн нэгтгэл, анги, салбарын тоог нэмэгдүүлж, Зэвсэгт хүчний ачаа, тээврийн боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр шаардлагатай техник, хэрэгслээр хангана” гэснийг хэрэгжүүлэх хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийг боловсруулаад байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох эрх зүйн зохицуулалтуудыг удирдлага болгон Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулсан ба улсын төсвөөс гарах зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцсон болно.

“Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгана.

Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог аргачлалын дагуу тооцох шаардлагагүй гэж үзсэн болно.

Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулснаар хоёр улсын “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-ийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хангагдаж, батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа улам гүнзгийрч, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, цэрэг-техникийн хамтын ажиллагаатай орны тоо нэмэгдэх, Япон Улсаас орчин үеийн батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэн авах, Монгол Улсын Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Мөн хэлэлцээрийн дагуу манай улсад Япон Улсаас орчин үеийн батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэн авах үйл ажиллагааг нь буцалтгүй тусламжийн хүрээнд хийгдэх тул улсын төсвөөс ямар нэгэн нэмэлт зардал шаардахгүй болно.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 12 сарын 03 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ-ээс

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны тэмдэглэл:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг **зөвшилцөх**.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг дэмжив.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРОО ХАРИУЦСАН РЕФЕРЕНТ

Б.ГАНДИЙМАА

**БАТЛАН ХАМГААЛАХЫН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БОЛОН ТЕХНОЛОГИ
ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ЯПОН УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦСӨН
ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 12 дугаар
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот


Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлсэн Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр, С.Эрдэнэболд, Н.Батсүмбэрэл нар төсөлтэй холбогдуулан ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл хэлэлцээрийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд Монгол Улсад хэрэгжиж байгаа гэрээ, хэлэлцээрийн талаар мэдээлэл авах, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд энхийг дэмжих ажиллагаанд манай цэргийн албан хаагчид амжилттай оролцож байгаа талаар дурдаад, хэлэлцээрийн хүрээнд авах техник, тоног төхөөрөмж нь цаг үеийн нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагад нийцэх эсэх, энэ талаар тодорхой мэдээллийг Батлан хамгаалах яамнаас танилцуулж байх талаар тус тус үг хэлсэн болно.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг дэмжсэн болно.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Г.ТЭМҮҮЛЭН

**ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ
АХМАДЫН ХОРОО**

13340 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 51,
Утас: 9908 0030, Факс: (976) 7015 2429,
Э-мэйл: akhmadkhoroo@gmail.com

2024.12.25 № 41
танай _____-ны № _____-т

**БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ
ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ГАЗРЫН ДАРГА ХУРАНДАА
Т.НАРАНХҮҮ ТАНАА**

Хариу хүргүүлэх тухай

Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлах “Соёрхон батлах тухай” хуулийн төсөл болон “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улс, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” – ийн материалтай танилцлаа.

Хууль батлагдсанаар батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлж, бүс нутагт цэргийн илтгэлцлийг бэхжүүлэх, цэрэг-техникийн хамтын ажиллагаатай орны тоо нэмэгдэж, Япон Улсаас орчин үеийн батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэн авах, Монгол Улсын Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдэх зэрэг ач холбогдолтой байх тул дэмжиж байна.

**ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН АХМАДЫН ХОРООНЫ
ДАРГА**



Д. БАДАМ



**"БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ
АХМАДЫН ХОРОО"
НИЙГЭМД ҮЙЛЧИЛДЭГ
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА**

13340 Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Дандарын гудамж 2,
Утас: (976-11) 451778, 3458
E-mail: seniordefence@gmail.com

2024-12-26 № 21
танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлах "Соёрхон батлах тухай" хуулийн төсөл болон "Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн материалтай танилцлаа.

Хууль батлагдсанаар батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлж, бүс нутагт цэргийн илтгэлцлийг бэхжүүлэх, цэрэг-техникийн хамтын ажиллагаатай орны тоо нэмэгдэж, Япон Улсаас орчин үеийн батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэн авах, Монгол Улсын Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх зэрэг ач холбогдолтой байх тул дэмжиж байна.

Хүндэтгэсэн:
ДАРГА. ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Д.МАГСАРЖАВ

**“БАТЛАН ХАМГААЛАХЫН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БОЛОН ТЕХНОЛОГИ
ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ЯПОН УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙГ УЛСЫН ИХ ХУРЛААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСЭГ**

дд	Овог, нэр	Албан тушаал	Регистрийн дугаар	Утасны дугаар
1	Сандагийн Бямбацогт	Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд	ПН74091412	99993823
2	Дагвадоржийн Ганхуяг	Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга	ЦД77082211	99091170
3	Төрбатын Наранхүү	Батлан хамгаалах яамны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга	ХЗ76090119	99137552
4	Гомбосүрэнгийн Энхболд	Батлан хамгаалах яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга, хуулийн зөвлөх	ХЛ66103110	96654413
5	Цогтсайханы Сэргэлэнбаатар	Батлан хамгаалах яамны Гадаад хамтын ажиллагааны газрын Олон улсын гэрээ, эрх зүй, ёслолын ажил хариуцсан ахлах мэргэжилтэн	HE90040474	80599902